

2013 онд УИХ-аас батлан гаргасан “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай” хуулийн бодит хэрэгжилтийг хангах тусгай хөтөлбөрийг батлан, үр дүнтэй хэрэгжүүлснээр гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх нэгдсэн тогтолцоо үүсэх боломж бүрдэх юм.

Эцэст нь гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөрийг үе шаттайгаар амжилттай хэрэгжүүлэх нь хууль хэрэгжүүлэгчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвараас ихээхэн хамаарах зүйл билээ.



Б.БЯМБАБААТАР
ХСИС-ийн Шүүхийн
шийдвэр гүйцэтгэлийн
сургуулийн Харуул
хамгаалалтын
тэнхимийн ахлах
багш, хошууч

ЦАГДАН ХОРИХ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ЧИГ ХАНДЛАГА, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Эрх зүйн шинжлэх ухаанд “Цагдан хорих” ойлголтыг хэрхэн тодорхойлсныг манай орны зарим эрдэмтэн, судлаачдын ном зохиолоос авч үзэхэд: академич С.Нарангэрэл (латин-arrestum: англи- confinement under guard: орос-заклучение под стражу) – эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэрэг бүртгэх мөрдөн байцаах, эрүүгийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх явцад, мөрдөн байцаалтын тусгаарлах байранд албадан хязгаарлах таслан шийдвэрлэх арга хэмжээний нэг¹¹⁰ юм гэж бичсэн байх бөгөөд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлтэй холбон дэлгэрэнгүй байдлаар тайлбарласан байдаг.

Мөн хууль зүйн ухааны доктор, профессор Б.Бат-Эрдэнэ “Цагдан хорих гэдэг нь сэжигтэн, яллагдагчийг шүүгчийн зөвшөөрлөөр, тодорхой хугаацаагаар нийгмээс тусгаарлаж эрх чөлөөг нь хязгаарлах албадлагын арга хэмжээ мөн”¹¹¹ гэж тодорхойлжээ.

¹¹⁰ С.Нарангэрэл. “Эрх зүйн эх толь бичиг” 2дахь хэвлэл. УБ. 2008 он. 552 дахь тал

¹¹¹ Б.Бат-Эрдэнэ. “МУ-ын ЭБШЭЗ-н Ерөнхий анги” УБ. 2004 он 265 дахь тал.

Өнөөгийн байдлаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хууль, “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай” хууль, “Эрүүгийн байцаан шийтгэх” хуулийн холбогдох заалтын хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, цагдан хорих байрууд нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг хорих, цагдан хорих ажиллагааг хэрэгжүүлэн, хүний эрхийн хангах, хорих байрны ахуй нөхцөлийг олон улсын жишиг, стандартад нийцүүлэх арга хэмжээг идэвхтэй зохион байгуулан ажиллаж байна.

Манай орны хууль тогтоох байгууллага “Эрүүгийн байцаан шийтгэх хууль”-ийн шинэчилсэн найруулгыг 2002 оны 01-р сарын 10-нд баталж, 2002 оны 09-р сарын 01 нээс түүнийг улс орон даяар мөрдөж эхэлсэн бөгөөд хуулийг хэрхэн нэг мөр ойлгож хэрэглэж, ялангуяа цагдан хорих таслан сэргийлэх ажиллагааг яаж хэрэглэж байгааг судлан, илэрсэн зөрчил, дутагдлыг давтан гаргуулахгүй байх арга хэмжээг тууштай зохион байгуулахад онцгойлон анхаарал хандуулж ирсэн.

Эрүүгийн байцаан шийтгэх энэ хуулийн 68 дугаар зүйлд: “Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ нь Эрүүгийн хуульд заасан хүнд, онц хүнд хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, түүнчлэн удаа дараа ял шийтгэгдэж байсан этгээд, онц аюултай гэмт хэрэгтэн дахин гэмт хэрэгт сэрдэгдсэн бол түүнийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлах, хэргийн бодит байдлыг тогтооход саад

учруулах, гэмт хэрэг дахин үйлдэхээс сэргийлэх зорилгоор цагдан хорьж болно”¹¹² гэж заасан.

Өмнө нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтнаас оргон зайлж болзошгүй, эсхүл оргон зайлсан бол хүндэвтэр гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг цагдан хорьж болно. Цагдан хорих зайлшгүй шаардлагатай бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч энэ тухай үндэслэл бүхий тогтоол үйлдэж, прокурорт танилцуулах бөгөөд прокурор нь шүүхэд танилцуулж батлуулна¹¹³... гэж заасан нь сэжигтэн яллагдагч, шүүгдэгчийг цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн гол эх сурвалж болон хуулийн дагуу хэрэгжүүлэх үндэслэлийн нэг болж байдаг. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дээрх заалтаас... хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтнаас оргон зайлж болзошгүй, эсхүл оргон зайлсан бол... гэсэн энэхүү заалт нь практикт зөрүүтэй байдлаар ойлгон хэрэглэсний улмаас хүний эрх эрх зөрчигдөх, тодорхой бус үндэслэлээр цагдан хорьж эрх чөлөөг нь хязгаарлах эрсдэлтэй тул ихээхэн маргаан дагуулдаг.

Шүүгч цагдан хорихоос татгалзсан бол сэжигтэн яллагдагчийг дахин цагдан хорих саналыг зөвхөн цагдан хорих шинэ, үндэслэл шалтгаан бий болсон тохиолдолд шүүхэд ирүүлнэ. “Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах, түүнийг хүчингүй болгох,

¹¹² “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2002 он, 12 дугаарт

¹¹³ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны, 12 дугаарт.

өөрчлөх талаар гаргасан шүүхийн шийдвэрт, тухайн шүүхийн Ерөнхий шүүгчид, түүний эзгүйд томилсон шүүгчид гаргана. Ийм гомдлыг 48 цагийн дотор хянан шийдвэрлэнэ” гэсэн заалт нь Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хүний эрхийг хангах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн зүгээс сэжигтэн, яллагдагчийг хууль бусаар хорих, хуулийг буруу хэрэглэх явдлаас сэргийлсэн шинжтэй заалт боловч сэжигтэн яллагдагчийг цагдан хорих хуулийн үндэслэл шаардлагыг илүү чангатгах, цагдан хорих шийдвэр гүйцэтгэх процессыг боловсронгуй болгох шаардлага байсаар байна.

Өнөөдрийн байдлаар 2002 онд батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль” болон 1999 онд батласан “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль”-ийн хүрээнд цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагаа зохицуулагдаж байгаа бөгөөд цаашид эдгээр хуулийн бүтэц, агуулга, зохицуулалтын хүрээнд нилээдгүй өөрчлөлт, шинэчлэлт хийгдэх нь тодорхой болоод байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хэмжээнд сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд цагдан хорих байрны албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлж, үйл ажиллагаандаа хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх, шуурхай, энэрэнгүй, хараат бус, хариуцлага хүлээдэг, сонор сэрэмжтэй,

мэдрэмжтэй, шударга байх зарчмыг удирдлага болгон ажиллах байдлыг хэвшил болгох шаардлага зүй ёсоор гарч ирнэ. Мөн алба хаагчдын мэдлэг ур чадвараас гадна тэнд ажиллагчдын ажлын дотоод зохион байгуулалт, техник хэрэгслийн хүрэлцээ, өдөр дутмын хэрэгжүүлэх ажил үүргийн хувиар, хөтлөгдөх баримт бичгийн жагсаалт, тодорхой нэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх аргачлал зэргийг тодорхой болгон журамлах зэрэгт гол анхаарлаа хандуулж, тодорхой ач холбогдол өгөн эрчимтэй ажил, арга хэмжээг авах болсон юм. Тухайлбал:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас цагдан хорих болон бусад төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тодорхой стандарт тогтоох үүднээс хэд хэдэн журмыг шинээр баталж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

ШШГЕГ-аас Цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд холбогдох журам.:

1. Хууль зүйн сайдын 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/209 дугаар тушаалаар батласан “Баривчлах цагдан хорих байрны дотоод журам”¹¹⁴;

2. Хууль зүйн сайдын 2014 оны 12 дугаар сарын 08-ний өдрийн А/230 дугаар тушаалаар батласан “Хорих ангийн дотоод журам”¹¹⁵;

3. Монгол Улсын хууль зүй, дотоод хэргийн сайд, эрүүл мэндийн

¹¹⁴ Баривчлах цагдан хорих байрны дотоод журам

¹¹⁵ Хорих ангийн дотоод журам

сайдын хамтарсан 2005 оны 03 сарын 25 өдөр 7/64 дугаар тушаалаар батласан "Цагдан хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эрүүл мэндийн байгууллагад эмчлэх, цагдан хорих байранд эмнэлгийн мэргэжилтэн ирж үйлчлэх журам"¹¹⁶;

4. Хууль зүйн сайдын 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/229 дугаар тушаалаар батласан "Сахилгын байр, тусгаарлах тасалгааны нөхцөл, журам"¹¹⁷;

5. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан 2008 оны өдрийн 205/94 дугаар тушаалаар батласан “Жишиг норматив тогтоох тухай”¹¹⁸;

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар:

1. “Тогтоол гүйцэтгэх газрын Нэгдсэн эмнэлгээс хорих анги, цагдан хорих болон тусгай мэргэжлийн эмнэлгүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах журам”¹¹⁹;

2. Сэжигтэн, яллагдагч, ялтны нийтийн хоолны “Үлгэрчилсэн загвар”¹²⁰;

¹¹⁶ Цагдан хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эрүүл мэндийн байгууллагад эмчлэх, цагдан хорих байранд эмнэлгийн ажилтан ирж үйлчлэх журам

¹¹⁷ Сахилгын байр болон тусгаарлах өрөөний нөхцөл журам

¹¹⁸ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаал

¹¹⁹ Тогтоол гүйцэтгэх газрын нэгдсэн эмнэлгээс хорих анги цагдан хорих болон тусгай мэргэжлийн эмнэлгүүдийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах журам

¹²⁰ Сэжигтэн, яллагдагч, ялтны нийтийн хоолны үлгэрчилсэн загвар

3. “Чанга, онцгой дэглэмтэй хорих анги, гяндангийн болон цагдан хорих төвийн гадна хамгаалалтыг зохион байгуулах журам”¹²¹ зэргийг батлан үйл ажиллагаандаа мөрдөн ашиглаж байна.

Мөн хорих байгууллагын албан хаагчдын өдөр тутам үүрэг гүйцэтгэх ажлын байранд тавигдах нийтлэг шаардлага, шаардлагатай техник хэрэгслийн шалгуур үзүүлэлтийг тогтоосон, түүнчлэн хоригдогч, албан хаагчдын хоорондын харилцааны хэм хэмжээг тодорхойлсон нийт 8 төрлийн стандартыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

Байгууллагын хэмжээнд хууль, эрхийн актийн шинэтгэл, бүтэц тогтолцооны томоохон өөрчлөлтүүд хийгдэж, түүнийг дагаад хоригдогсдын болон албан хаагч, иргэдийн аливаа хандлага хувьсан өөрчлөгдөж, эрх зүйн мэдлэг дээшлэх хандлагатай болсон. Иймд дээрх журам заавар, үйл ажиллагааны стандартууд нь цагдан хорих болон бусад төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нэг мөр хэрэгжүүлэхэд нэн шаардлагатай байсан юм.

Нөгөөтэйгөөр цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд материаллаг нөхцөлийг сайжруулан хорих байрны барилга байгууламж, эрүүл ахуйн зэрэг бусад хэм хэмжээ, стандартыг дагаж мөрдүүлэх ажил чухал хүчин зүйл болдог. Иймээс цагдан хорих шийдвэр гүйцэтгэх

¹²¹ Чанга, Онцгой дэглэмтэй хорих анги болон Гяндангын болон цагдан хорих төвийн гадна хамгаалалтыг зохион байгуулах журам

ажиллагаанд холбогдох стандартуудыг батлан мөрдөж ажиллаж байна:

1. “Хоригдогсдын эрхийг хангахад чиглэсэн цагдан хорих, хорих ял эдлүүлэх ажиллагааны стандарт” /CS 11-0238-2013/¹²². Уг стандартын төслийг Улсын ерөнхий прокурорын газар, Хүний эрхийн үндэсний комисс, “Эмнэсти интернэшнл” зэрэг байгууллагад хүргүүлэн, санал дүгнэлтийг нь авч боловсруулсан.

2. “Цагдан хорих төвийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт” /CS 11-0237:2013/¹²³ зэрэг батлагдсан байна.

Дээрх стандартуудыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, баривчлах, цагдан хорих байр тэдгээртэй адил дэглэм бүхий байгууллагууд дахь мэргэжлийн үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт болон судалгааны арга, хэлбэрийг тодорхойлох зэрэг үндсэн чиглэлийг хамарч, ажлын үр дүнг үнэлэх, холбогдох байгууллагаас үйл ажиллагаанд нь хяналт тавихад ашиглана. Улмаар хорих байгууллагын бүх албан тушаалтан мөрдөх нэгдсэн дүрэм тогтоож хорих анги, албаны болон мэргэжлийн онцлогийг тусгасан үйл ажиллагааны баримтжуулалтыг нэмэлтээр тогтоож, баталгаажуулан мөрдүүлэх нь практикт чухал ач холбогдолтой юм.

Цаашид харуул хамгаалалтын болон бусад албан хаагчдын албан үүргээ зохих хэмжээнд хэвийн гүйцэтгэх

нөхцөл боломжийг бүрдүүлэн хоригдсон этгээдийг олон нийтээс тусгаарлах, тэднээс үйлдэж болзошгүй гэмт үйлдэл, халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, түүнчлэн тэдний аюулгүй байдлыг хангах, хорих байгууллагын албан хаагчдын өдөр тутам гүйцэтгэх үйл ажиллагааг тодорхойлсон хууль, журам, хэм хэмжээг нэг мөр хэрэгжүүлэх, хөтлөгдөж буй баримт бичгийн агуулга, загварыг батлах, бүрдлийг сайжруулах, үйл ажиллагааны баримтжуулалтад тавигдах нийтлэг шаардлагыг тогтоож, мөрдүүлэх зорилготой ажлыг тогтмол зохион байгуулах ёстой.

Эдгээр онолын болон практик шинжтэй ажиллагаануудыг тодорхой судалгаанд үндэслэн цогц байдлаар авч хэрэгжүүлснээр сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зорилго хангагдах боломжтой юм. Ингэснээр сэжигтэн яллагдагчийн эрх зүйн байдлыг хуульд заасан хэмжээнд хангаж ажиллахаас гадна, албан хаагчдын ажлын нөхцөл боломжийг дээшлүүлэх, эрх ашиг, аюулгүй байдлыг хангах тухай асуудал хурцаар тавигдах хандлагатай байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хүний эрхийг хангах, хорих нөхцөл, журмыг сайжруулах шат дараалсан олон арга хэмжээг авч хэрэгжүүлж ирсэн бөгөөд сүүлийн жилүүдийн байдлаар зөвхөн цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр зохион байгуулалтын дараах ажлуудыг авч хэрэгжүүлжээ. Үүнд:

¹²² Хоригдогсдын эрхийг хангахад чиглэсэн цагдан хорих, хорих ял эдлүүлэх ажиллагааны стандарт

¹²³ Цагдан хорих төвийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт

2013-2015 онд шинээр Өвөрхангай аймгийн Хархорин дахь шийдвэр гүйцэтгэх албаны цагдан хорих байрыг хорих 423 дугаар ангийн хамгаалалтын бүсэд шилжүүлэн байршуулсан. Булган аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх албаны цагдан хорих байрыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дотоод орлогын эх үүсвэрээр 272 сая төгрөгийн өртөг бүхий 50 хоригдогчийн багтаамжтай, 16 хорих өрөөтэй олон улсын жишигт нийцсэн цагдан хорих байр Орхон аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх албаны 250 хоригдогчийн багтаамжтай цагдан хорих, хорих ял эдлүүлэх байр Увс, Дорнод, Дундговь, Говь-алтай, Зүүнхараа дахь Шийдвэр гүйцэтгэх албадууд 200- 650 сая төгрөгийн өртөгтэй 80-100 хоригдогчийн багтаамж бүхий цагдан хорих байруудыг ашиглалтанд оруулсан зэрэг олон төрлийн бүтээн байгуулалт, цагдан хорих байрны орчин нөхцлийг дээрдүүлэхэд чиглэгдсэн ажлуудыг эрчимтэй өрнүүлж байгаа нь цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагааг олон улсын түвшинд хүргэх, үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн чухал ач холбогдолтой ажил болж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хэмжээнд Цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хүрээнд хийгдэж буй зарим ажлуудын /Нийт 25 цагдан хорих байр/ 2015 оны жилийн эцсийн тоон үзүүлэлтийг авч үзэхэд:

2013-2015 онд цагдан хорих 461 дүгээр анги болон аймгуудын цагдан хорих байрны баривчлах байранд шинээр 7767 хоригдогчийг хүлээн авч, хорих ангид 2061, баривчлах ял эдлүүлэх байранд 774 ялтныг

шилжүүлж, 923 хоригдогч суллагдаж, 1759 батлан даалтанд гаргаж ажилласан бөгөөд 2015 оны хагас жилийн байдлаар 1188 сэжигтэн, яллагдагч хоригдож байна ¹²⁴. Хоригдсон этгээдийн гаргасан гэмт хэрэг, зөрчлийг авч үзвэл 2011-2013 онд буурч 2014 онд өсч 2011-2015 онд буурсан үзүүлэлттэй байна.

№	Зөрчил	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	Нийт
1	АХ-ын хууль ёсны шаардлага эсэргүүцсэн	24	7	10	3	20	64
2	Бусдыг зодож дарамталсан	13	8	10	18	12	61
3	Гар утас ашигласан	17	8	2	17	16	60
4	Хориотой эд зүйл хадгалсан	12	16	15	2	1	46
5	Эд зүйл булаасан, дээрэмдсэн	8	0	2	0	1	11
6	Бусдын биед гэмтэл учруулсан	0	6	0	0	1	7
7	Архи уусан	0	0	0	0	0	0

Дүгнэлт

Манай улсын цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж буй дараах асуудлууд байна. Үүнд:

- А. Хоригдогчдын эрх зүйн байдал
- Б. Хорих хугацаа
- В. Хорих нөхцөл

¹²⁴ Н.Гантулга “Хүний эрх ба хорих ял” УБ хот 2015он 192-р тал

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, албан хаагчдыг идэвхжүүлэн алдаа дутагдал, ололт амжилтыг дүгнэн, ажлын харилцан уялдаа

нодөгчлөх” нэг мөр баримтлан цагдан хорих байрны орон тоог тогтоож бие бүрэлдэхүүн орон тоогоор ажиллуулах. Мөн орон нутгийн цагдан хорих байранд нийгмийн ажилтан, эмч, сэтгэл

Хоригдогсдоос гарсан зөрчлийн тоон үзүүлэлт



холбоог нягтруулж, харуул хамгаалалтын хяналт сул цэгт телекамер нэмж суурилуулан, ашиглалт, эвдрэл гэмтлийг засварлуулж, цагдан хоригдогч, ялтны хоол, хүнс, ахуй нөхцөлд анхаарч ажилласнаар хоригдогчийн үйлдэх зарим төрлийн зөрчил тодорхой хувиар буурсан үзүүлэлт гарч байна.

Дээрх тоон үзүүлэлтээс харахад сэжигтэн яллагдагч, шүүгдэгчийг цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажил үүргийн чухал хэсэг болжээ.

Санал

1. Оууль зэй, доноод оёддэс йн нгйд, Нсйаё сйн өгё арглг, ошдс лёс дсйн нгйдүн 2008 онд 205/94 дугаар хамтарсан тушаалаар батласан “Жсг сә

зүйчийн орон тоог бий болгох.

2. Албан хаагчдын ажлын байрны орчин нөхцлийг сайжруулах, үйл ажиллагааг нь журамлан тодорхойлсон эрх зүйн зохицуулалтыг оновчтой болгох, хөтлөх баримт бичгийн нэгдсэн стандартыг тогтоон мөрдүүлэх болон хоригдогчдыг олон нийтээс тусгаарлах, үйлдэж болзошгүй гэмт үйлдэл, халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, аюулгүй байдлыг хангах чиглэлээрх судалгааны ажил, практик ажилтнуудын санал санаачлагыг дэмжин ажил хэрэг болгох.